



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 121

Төрийн ордон, Улаанбаатар хот

**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ
ТУХАЙ**

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, 76.2, 76.5 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр тус тус томилсугай.
- 2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Навагчамбын Баасанжав, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг, Ренчиндоржийн Онончимэг, Дорждамбын Зүмбэрэллхам нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.
- 3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.УЧРАЛ